



САНГИЙН САЙД  
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,  
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,  
<http://www.mmhi.gov.mn>

2019.08.30 № 01/2458  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн  
үзэл баримтлал-2030”-ийн хэрэгжилтэд  
хийсэн ХШҮ-ний тайлан хүргүүлэх тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” дахь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хүргүүлж байна.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” дахь тус яамны дангаар хэрэгжүүлэх 3 зорилтын 10 үйл ажиллагаа, толгойлон хэрэгжүүлэх 1 зорилтын 1 үйл ажиллагаа, хамтран хэрэгжүүлэх 3 зорилтын 4 үйл ажиллагааны биелэлт 2019 оны эхний хагас жилийн байдлаар 42.0 хувийн хэрэгжилттэй байна.

1.УУХҮЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2019.08.30-ны өдрийн хурлын тэмдэглэл, 1 хуудас,

2.“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, хавсралтын хамт 121 хуудас,

Хавсралт ~~121~~ хуудастай. +5



Д.СУМЪЯАБАЗАР



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2019 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн Н.Баатар хийв

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, тайланг холбогдох журмаар тогтоосон хугацаанд нь Сангийн яаманд хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИЙН БИЧИЙН  
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



**“МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”-ЫН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
/2019 оны эхний хагас жилийн байдлаар/

2019 оны 08 дугаар сарын 28-ны өдөр

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Их Хурлын 2016 оны 16 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээ тус бүрээр нь хяналтанд авч, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, шийдвэр гаргах түвшний удирдлагуудыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Эдийн засгийн тогтвортой хөгжлийн “Аж үйлдвэрийн салбар”, “Эрдэс баялгийн салбар”, “Бизнесийн таатай орчин”, Тогтвортой хөгжлийн засаглал 4 стратегийн 8 зорилт, 15 үйл ажиллагааг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь хэрэгжүүлэхээр тусгагдсан. Эдгээрээс 10 арга хэмжээг дангаар, 1 арга хэмжээг толгойлон, 4 арга хэмжээг хамтран хэрэгжүүлнэ

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг тус тус удирдлага болгов.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу нотлох баримтыг үндэслэж, мөн зорилтыг хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах үр дүнг үнэлгээ хийх үед хүрсэн бодит үр дүнгийн түвшин, зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлтэй харьцуулан, биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг өгсөн.

**ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгагдсан Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны хариуцан хэрэгжүүлэх 8 зорилт 15 арга хэмжээний биелэлт нь 2019 оны эхний хагас жилийн байдлаар 42.0 хувийн биелэлттэй, үүнээс 2 арга хэмжээ нь “үр дүнтэй” 100 хувь, 1 арга хэмжээ нь

“тодорхой үр дүнд хүрсэн” 70 хувь, 9арга хэмжээ нь “эрчимжүүлэх шаардлагатай” 40 хувийн хэрэгжилттэй, 3 арга хэмжээ нь “үр дүнгүй” 0 хувьтай байна.

Үзэл баримтлалын эдийн засгийн тогтвортой хөгжлийн аж үйлдвэрийн салбарын 1 дугаартай зорилт 40%, 3 дугаартай зорилт 33.3%, 4 дугаартай зорилт 40%, Эрдэс баялгийн салбарын 1 дугаартай зорилт 80%, 2 дугаартай зорилт 40%, Бизнесийн таатай орчны 1 дугаартай зорилт 0%, Тогтвортой хөгжлийн засаглалын 3 дугаартай зорилт 40%, 4 дугаартай зорилт 0% хувийн биелэлттэй дүгнэгдсэн (Хүснэгт 1).

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний нэгтгэл, (2019 оны эхний хагас жилийн байдлаар)

Хүснэгт 1

Зорилтын дугаар		Хэрэгжүүлэх үйл ажиллагаа				Хэрэгжилтэд өгөх үнэлгээ, хувь				Хэрэгжилт, хувь
		Тоо	Дангаар	Толгойлон	Хамтран	100	70	40	0	
<b>2.1. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ</b>										
2.1.3. Аж үйлдвэрийн салбар	Зорилт 1.	1			1			1		40,0
	Зорилт 3.	6	6					5	1	33,3
	Зорилт 4.	1	1					1		40,0
2.1.4. Эрдэс баялгийн салбар	Зорилт 1.	3	3			2	1			80,0
	Зорилт 2.	1		1				1		40,0
2.1.7. Бизнесийн таатай орчин	Зорилт 1.	1			1				1	0,0
<b>2.4. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ</b>										
	Зорилт 3.	1			1			1		40,0
	Зорилт 4.	1			1				1	0,0
<b>Нийт дүн</b>		<b>15</b>	<b>10</b>	<b>1</b>	<b>4</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>9</b>	<b>3</b>	<b>42,0</b>

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай; илүү сайн тодорхойлох шаардлагатай, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй дараахь 12 арга хэмжээ байна Үүнд:

“Эрчимжүүлэх шаардлагатай” 40 хувийн биелэлттэй 9 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлэх 6, толгойлох хэрэгжүүлэх 1, хамтран хэрэгжүүлэх 2 арга хэмжээ

- 2.1.3. Аж үйлдвэрийн салбар. Зорилт 1. Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх. 1. Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэх, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.

2. **Зорилт 3.** Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана. **1.** Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах,
3. **2.** зэс хайлуулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх,
4. **3.** алт цэвэршүүлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх
5. **4.** газрын тос үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх
6. **5.** байгалийн хий, занар, нүүрс боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх
7. **Зорилт 4.** ар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.
8. **2.1.4. Эрдэс баялгийн салбар Зорилт 2.** Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. **1.** Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах.
9. **2.4.Тогтвортой хөгжлийн засаглал Зорилт 3.** Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.

**“Үр дүнгүй”** 0 хувийн биелэлттэй 3 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлэх 1, толгойлох хэрэгжүүлэх 1, хамтран хэрэгжүүлэх 2 арга хэмжээ

1. **2.1.3. Аж үйлдвэрийн салбар. Зорилт 3.** Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана. **6.** химийн болон бордооны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх
2. **2.1.7. Бизнесийн таатай орчин. Зорилт 1.** Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлнэ.
3. **Зорилт 4.** Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ**

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжсэн “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 8 зорилтын 15 арга хэмжээний биелэлт нь 2019 оны эхний хагас жилийн байдлаар **42.0** хувьтай үнэлэгдэв.
2. Эрдэс баялгийн салбарын стратегийн зорилтын геологийн салбарын хөгжлийг дэмжинэ зорилтын хэрэгжилтийг хангалттай сайн гүйцэтгэн ажилласан ч ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх зорилтыг Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулахаар тусгасан ба бодлогын баримт бичгийн төлөвлөлтийг үндэслэлгүй, бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулахгүй төлөвлөж байна.

3. “Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх”, “Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана”, “Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана”, “Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ”, “Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.” 5 зорилтын хэрэгжилт удаашралтай байна.
4. “Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлнэ.”, “Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.” 2 зорилтыг хэрэгжүүлээгүй тасарсан байна.
5. Үзэл баримтлалын бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа 2.1.7 дугаартай, 2.4 дугаартай зорилтын биелэлтийг тайлагнаагүй орхигдуулсан нь асуудал хариуцсан нэгжийн зарим албан хаагчид нь тус яамны “хамтран” хэрэгжүүлэх зорилт арга хэмжээг хяналтандаа авч, үйл ажиллагаандаа тусган анхаарч ажиллахгүй байгаатай холбоотой.
6. Үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулаагүй тул харьцуулан дүгнэх шалгуур үзүүлэлт, суурь үзүүлэлт байхгүй тул хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байна.
7. Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концесийн гэрээ 2014 онд хүчин төгөлдөр болсноос хойшхи 5 жилийн хугацаанд удаашралтай байгааг хурдасгаж, богино хугацаанд үр дүнд хүрэхийн тулд төмрийн хүдэр хайлуулах зуухыг ажиллуулах нүүрс, зуухыг хөргөх үйлдвэржилтийн гүний усны нөөц болон хот суурин газрын барилга байгууламж, дэд бүтцийн суурийн судалгаа, ундны усны нөөц тогтоох, бүтээн байгуулалтын барилгын материалын нөөц тогтоох зэрэг геологийн иж бүрэн судалгаа хийгдсэн талаар дүгнэлт зөвлөмж гаргаагүй байна.
8. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн байршлыг хот суурин газар байгуулах, барилга байгууламж, үйлдвэржилт, ундны усны нөөц, дэд бүтэц зэрэг өргөн хүрээнд нотлох баримтанд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт, зөвлөмж гаргаж, хэрэгжүүлэх талаар бодлогын түвшинд анхаарахгүйн улмаас үйлдвэр барих байршлыг байнга өөрчилж, хугацаа алдаж байна.
9. Үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах чиг үүрэг бүхий төрийн өмчит “Эрдэнэс алт ресурс” ХХК байгуулагдан ажиллаж байгаа талаарх нотлох баримтыг тайланд хавсаргаагүй байна.
10. Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг дотоодоос хангахын тулд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт 20 гаруй талбай, эрлийн ажлуудын геологийн судалгааны ажлын үр дүн буюу нөөц бэлтгэлийн ажлыг орхигдуулсаар байгаа байдалд бодлогын түвшинд анхаарах шаардлагатай байна.
11. Химийн болон бордооны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж эхлээгүй байна.

12. Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ зорилтын 2, 3 дах үйл ажиллагааны биелэлтэнд судалгаанд хамрагдсан газар нутгийн хэмжээнд шинээр тогтоогдсон болон баталгаажсан метал, метал бус, шатах болон гений ус зэрэг төрөл бүрийн ашигт малтмалын илрэл, эрдэсжсэн цэг, геохими, геофизикийн гажлын талаарх мэдээллийг тайландаа дурдаж, хүрсэн үр дүнг тайлагнахгүй байна.
13. Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ зорилтын хүрээнд Таван толгойн нүүрсний ордын талаар тайлагнаж, бусад Оюу толгой, Цагаан суварга зэрэг ордуудын талаар бодлогын түвшинд хэрэгжүүлсэн ажлыг тайлагнаагүй. Толгойлон хэрэгжүүлж байгаа яамны хувьд бусад яамтай хэрхэн хамтран ажилласан талаар бичээгүй байна.
14. Авилгатай тэмцэх газраас өгсөн шударга байдлын 2018 оны үнэлгээгээр тус яам нь сүүлийн байранд орсон ба ТЗУГ-ын асуудал хариуцсан албан хаагч нь 2016-2018 оныг хамруулан өссөн дүнгээр биелэлтийг тайлагнаагүй.
15. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал хариуцсан мэргэжлийн нэгжүүд болон нийтлэг чиг үүрэгтэй төрийн захиргааны удирдлагын нэгжийн албан хаагчид нь хариуцсан асуудлаар боловсруулсан бодлого, төлөвлөлтийг холбогдох бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, үзэл баримтлалын зорилт, арга хэмжээг хяналтандаа авах, хэрэгжилтийн үр дүнд анхаарах, биелэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоосон хугацаанд товч тодорхой тайлагнах, дэлгэрэнгүй тайланг танилцуулга хэлбэрээр, холбогдох нотлох баримтуудын хамт хавсаргах талаар санаачлагатай, хариуцлагатай ажиллахгүй байна.

#### **ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

1. Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны асуудал хариуцсан мэргэжлийн нэгжийн удирдлага, албан хаагчид нь чиг үүрэг, хариуцсан асуудлаар боловсруулж байгаа бодлого, төлөвлөлт болон бодлогын баримт бичгийн биелэлтийг тайлагнахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай байна.
2. Үзэл баримтлалд тусгагдсан 15 арга хэмжээний эрчимжүүлэх шаардлагатай 9 арга хэмжээ, үр дүнгүй 3 арга хэмжээний хэрэгжилтэд анхаарч, бодитой үр дүнд хүргэхэд чиглэн ажиллах шаардлагатай байна.
3. Стратегийн бодлого төлөвлөлтийн газар нь бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан боловсруулан батлуулах шаардлагатай байна.
4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл заалт, бодлогын баримт бичгүүдийн зорилт арга хэмжээг уялдуулах арга хэмжээг хэрэгжүүлж, утга агуулгаар нь багцлан яамны стратегийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байна.
5. Бодлогын баримт биелэлтэнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дээрхи дүгнэлтэнд тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хавсралт:

1. "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын хэрэгжилтийн тайлан (2019 оны эхний хагас жилийн байдлаар), 13 хуудас,
2. Бодлогын баримт бичгийн биелэлтийн хавсралтууд, 108 хуудас  
Нийт 121 хуудас.

## УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

2019 оны 08 дугаар сарын 30-ны өдөр

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга



Г.Ганхүү

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж,  
ХШҮ-ний тайлан боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн



Н.Баатар /2019.08.30/

Н.Баатар /2019.08.30/

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн:  
ХШҮДАГ-ын мэргэжилтэн



Д.Батнайрамдал

мэргэжилтэн



Д.Болортуяа

**“МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2019 оны 8 дугаар сарын 28-ны өдөр

Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, зорилт	Зорилт	I үе шат (2016-2020) Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь		Зорилтот түвшин (2016-2020)	Хүрсэн түвшин (2019 оны эхний хагас жилийн байдлаар)	хувь	Дэлгэрэнгүй тайлбар (Хэрэгжээгүй шалтгаан)
				2014 он	2014 Түвшин				
1	2	3	4	5	6	7	8	9	10
<p>УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл батимтлал-2030</p> <p><b>2.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ</b></p> <p>Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийнзасгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах үйлдвэр</p>	<p><b>2.1.3.АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР</b></p> <p><b>Зорилт 1.</b></p> <p>Аж үйлдвэрийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх</p>	<p>1. Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэх, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлж, түүхий эдийн бүрэн боловсруулалтыг 60 хувьд хүргэх.</p>					<p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.7-д “үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, металл хийц, машин үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэсэн заалтыг оруулсан. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/180 дугаар тушаалаар батлагдсан “Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 7 дугаар зорилтын хүрээнд “үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, металл хийц, машины үйлдвэрлэлийг хөгжүүлэх” үйл ажиллагааны 8 чиглэлийн дагуу хүнд үйлдвэрийг цогцоор хөгжүүлэх, дэд бүтэц, тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээг бий болгох, дэвшилтэт технологид суурилсан экспортын чиглэлийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх заалтуудыг тусган ажиллаж байна.</p>	<b>40</b>	

боловсруулах, түрээс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.

					Мөн “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах”, “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах”, “Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах”, “Нийлэг байгалийн хий үйлдвэрлэх” “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хавсралт 1.		
<b>Зорилт 1-ийн хэрэгжилт</b>	<b>Дүгнэлт. 2.</b> Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концесийн гэрээ 2014 онд хүчин төгөлдөр болсноос хойшхи 5 жилийн хугацаанд удаашралтай байгааг хурдасгаж, богино хугацаанд үр дүнд хүрэхийн тулд төмрийн хүдэр хайлуулах зуухыг ажиллуулах нүүрс, зуухыг хөргөх үйлдвэржилтийн гүний усны нөөц болон хот суурин газрын барилга байгууламж, дэд бүтцийн суурийн судалгаа, ундны усны нөөц тогтоох, бүтээн байгуулалтын барилгын материалын нөөц тогтоох зэрэг геологийн иж бүрэн судалгаа хийгдсэн талаар дүгнэлт зөвлөмж гаргаагүй байна. <b>Хэрэгжсэн хувь 40%</b>						
<b>Зорилт 3</b> Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.	1. Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах,				Манай улс 2017 онд нийт 1,3 сая мянган тонн автобензин, дизелийн түлш импортлосноос K5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин, дизелийн түлш 8,7 хувийг эзэлж байсан бол 2018 онд 1,49 сая тонн автобензин, дизелийн түлш импортлосноос K5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин, дизель түлш 186 мянган тонн буюу нийт шатахууны 12,8%-д хүрсэн. 2019 оны 08 сарын 01-ний байдлаар 1039,6 мянган тонн шатахуун импортлосноос K5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин, дизель түлш 133,4 мянган тонн буюу 12,8% болоод байна. Энэ оны эцсээр K5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин, дизель түлшний импорт нийт шатахууны 20%-д хүрэх боломжтой. Автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг чанар, стандарттай уялдуулан эрх зүйн орчин бүрдүүлэх чиглэлээр манай яамнаас холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа бөгөөд татварын оновчтой зохицуулалтаар K5 /Евро-5/ стандартын шатахууны импорт, хэрэглээг дэмжих шаардлагатай байна.	40	Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр 2023 онд ашиглалтад орсноор Евро-5 стандартын 560 мян.тн/жил автобензин, 670 мян.тн/жил дизель түлш үйлдвэрлэж, түлш шатахууны дотоодын хэрэгцээний 80 гаруй хувийг хангана.

2. зэс хайлуулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх,	Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар			Үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах	Төслийн нэгж байгуулах тухай ЗГ-ын 2016 оны 107 дугаар тогтоолоор Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байна. Төслийн хүрээнд дараах асуудлуудыг шийдвэрлээд байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>•Үйлдвэрийн байршил, газрын асуудал шийдэгдсэн.</li> <li>•Ус хангамжийг эхний ээлжинд газрын доорх уснаас хангахаар шийдвэрлэсэн.Цаашид гадаргын уснаас хангахаар ТЭЗҮ боловсруулах ажил шийдэгдэх шатандаа байна.</li> <li>•Үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах тендэр явагдаж байна.</li> <li>•Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна. Хавсралт 2</li> </ul>	40	
3. алт цэвэршүүлэх үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх	Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх	0	0	Алтны олборлолтын хэмжээ нэмэгдэх	Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төсөл Монгол улсын нутаг дэвсгэрт үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах чиг үүрэг бүхий төрийн өмчит “Эрдэнэс алт ресурс” ХХК байгуулагдан ажиллаж байна. Төслийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>•Үйлдвэрийн ТЭЗҮ хийгдсэн;</li> <li>•Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, дэд бүтцийн болон инженер геологийн судалгааг гүйцэтгэж байна; Эдгээр ажлуудыг 2019 оны IV улиралд багтаан хүлээн авна.</li> <li>•Мөн газрын асуудал шийдэгдсэн.</li> </ul>	40	

4. газрын тос үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх	Газрын тос боловсруулах үйлдвэр болон түүхий тос дамжуулах хоолойн барилгын ажлыг эхлэх бэлтгэлийг хангах, хувиар	Барилгын ажлын явц, хувиар	30	Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах	УИХ-аас 2017.05.31-ний өдөр МУ-ын ЗГ болон БНЭУ-ын Экспорт-Импорт банк хоорондын 1 тэрбум ам.долларын Зээлийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон баталсан бөгөөд ЗГ-ын 2017 оны 59 дүгээр тогтоолоор дээрх хэлэлцээрийн хүрээнд "Газрын тос боловсруулах үйлдвэр барих" төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн газрын 2017 оны 92 дугаар тогтоолын дагуу 2017.04.04-ний өдөр "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" ТӨХХК байгуулагдан Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барих төслийн ажлыг гүйцэтгэж байна. Хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр газрын тос боловсруулах үйлдвэрийн гадна дэд бүтцийн ажлыг 2018 оны 6 дугаар сараас эхлүүлж, төмөр зам, авто зам болон цахилгаан дамжуулах агаарын шугам барьж байгуулах төслүүдийг хэрэгжүүлж байна. Газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд, ахуйн хэрэгцээнд шаардлагатай усны хангамжтай холбоотой асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019.06.04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн, 21/14 дүгээр зөвлөмжөөр газрын тос боловсруулах үйлдвэрийн технологийн болон унд, ахуйн хэрэгцээнд шаардлагатай 106л/с усыг Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт орших	40	
--	---	----------------------------	----	--	---	----	--

					Бор хөөврийн говийн газрын доорх усны ордоос хангах асуудлыг яаралтай шийдвэрлэхийг ЗГ-т зөвлөмж болгосон. ЗГ-ын 2019.07.03-ны өдрийн 284 дүгээр тогтоолоор дээрхи асуудлыг судалж шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасан. Эдгээр тогтоол, шийдвэрүүд гарснаар газрын тос боловсруулах үйлдвэрийн ус хангамжтай холбоотой асуудлыг Усны тухай хуулийн дагуу түргэн шуурхай шийдвэрлэх, жил бүр ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл гаргуулах, гэрээ байгуулах нөхцөл бүрдээд байна		
5. байгалийн хий, занар, нүүрс боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх	Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх	0	0		Засгийн газрын 2016 оны өдрийн 107 дугаар тогтоолыг үндэслэн УУХҮС-ын 2016.10.21-ний өдрийн А/43 дугаар тушаалаар УУХҮЯ-ны дэргэд "Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр барих" төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулан ажиллаж байна. Төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>•ТЭЗҮ хийгдэж хүлээн авсан</li> <li>•БОННҮ -г хүлээж авах шатандаа байна.</li> <li>•Үйлдвэрийн байршил, газрын асуудал шийдэгдсэн.</li> <li>•Хий дамжуулах шагамын трассын асуудал шийдэгдэх шатандаа байна. Хавсралт 3</li> </ul>	40	
6. химийн болон бордооны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх						0	

	<b>Зорилт 3-ын хэрэгжилт</b>	<p><b>Дүгнэлт. YA-2.</b> Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийн байршлыг хот суурин газар байгуулах, барилга байгууламж, үйлдвэржилт, ундны усны нөөц, дэд бүтэц зэрэг өргөн хүрээнд нотлох баримтанд тулгуурласан шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт, зөвлөмж гаргаж, хэрэгжүүлэх талаар бодлогын түвшинд анхаарахгүйн улмаас үйлдвэр барих байршлыг байнга өөрчилж, хугацаа алдаж байна. <b>YA-3.</b> Үнэт металл эрэх, хайх, олборлох, цэвэршүүлэх, борлуулах чиг үүрэг бүхий төрийн өмчит "Эрдэнэс алт ресурс" ХХК байгуулагдан ажиллаж байгаа талаарх нотлох баримтыг тайланд хавсаргаагүй байна. <b>YA-4.</b> Газрын тос боловсруулах үйлдвэрийн түүхий эдийн нөөцийг дотоодоос хангахын тулд газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт 20 гаруй талбай, эрлийн ажлуудын геологийн судалгааны ажлын үр дүн буюу нөөц бэлтгэлийн ажлыг орхигдуулсаар байгаа байдалд бодлогын түвшинд анхаарах шаардлагатай байна. <b>YA-6.</b> Химийн болон бордооны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж эхлээгүй байна <b>Хэрэгжсэн хувь 38.3%</b></p>						
<p><b>Зорилт 4.</b> Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, уул уурхай, барилга, дэд бүтцийн байгууламжийн үндсэн нэр төрлийн төмөр, ган хийцийн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангана.</p>	<p>1.Жилд 100.0 мянган тонн ган бөмбөлөг, тээрмийн хуяг, бусад эд анги үйлдвэрлэх хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийн үйлдвэрийг ашиглалтад оруулах.</p>	<p>Үйлдвэр ашиглалтад орох</p>		<p>Бүтээн байгуулалт эхэлсэн байна.</p>	<p>Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах</p>	<p>"Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах төсөл"-ийг "Кью Эс Си ХХК (Дарханы төмөрлөгийн үйлдвэр) хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус төслийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төслийн ТЭЗҮ хийгдсэн.</li> <li>• БОННУ хийгдэж байна.</li> <li>• Мөн "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК нь жилд 25.000 тонн/жил хүчин чадалтай ган бөмбөлгийн үйлдвэрийг 2017 онд ашиглалтад оруулсан. Хавсралт 1, 4.</li> </ul>	<p>40</p>	<p>Төслийн хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас төсөл хугацаандаа хэрэгжих боломжгүй болж, бүтээн байгуулалтын ажлууд хойшлогдсон.</p>
	<b>Зорилт 4-ийн хэрэгжилт</b>	<p><b>Дүгнэлт.</b> Уул уурхайн металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх концесийн гэрээ 2014 онд хүчин төгөлдөр болсноос хойшхи 5 жилийн хугацаанд удаашралтай байгааг хурдасгаж, богино хугацаанд үр дүнд хүрэхийн тулд төмрийн хүдэр хайлуулах зуухыг ажиллуулах нүүрс, зуухыг хөргөх үйлдвэржилтийн гүний усны нөөц болон хот суурин газрын барилга байгууламж, дэд бүтцийн суурийн судалгаа, ундны усны нөөц тогтоох, бүтээн байгуулалтын барилгын материалын нөөц тогтоох зэрэг геологийн иж бүрэн судалгаа хийгдсэн талаар дүгнэлт зөвлөмж гаргаагүй байна <b>Хэрэгжсэн хувь 40%</b></p>						
<p><b>2.1.4. ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАР</b></p>								

<p>2.1.4. Эрдэс баялгийн салбар <b>Зорилт 1.</b> Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.</p>	<p>1. Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг иж бүрнээр гүйцэтгэх чадавхийг бэхжүүлж, судалгааны ажлын арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах,</p>					<p>Ашигт малтмалын тухайн төрөл тус бүрээр эрэл, хайгуулын ажлыг явуулах аргачилсан зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн санхүүжилтээр алтны үндсэн болон шороон орд, төмөр, хайлуур жонш, газрын тос гэсэн 5 төрлийн ашигт малтмалын эрэл, хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмж боловсруулж, 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх Канадын СЕСМИМ төсөлтэй хамтран 1 /зэс/ ашигт малтмалын эрэл, хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг боловсруулж, 7 дугаар сард ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. . Цацраг идэвхт ашигт малтмал (уран, тори), нүүрсний "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг ордын хайгуулд хэрэглэх аргачилсан зөвлөмж"-ийг 2018 онд ЭМБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хавсралт 5, 6</p>	<p>100</p>	<p>Төлөвлөлтийн дагуу хийгдэж байна.</p>
---	--	--	--	--	--	--	------------	--

<p>2. Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулан,</p>	<p>Нийт хамруулах газар нутгийн хэмжээ, хувь</p>			<p>100</p>	<p>Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлаар нутаг дэвсгэрийн 92%-ийг бүрэн хамруулсан бөгөөд 2019 онд Улсын геологийн зураглал /УГЗ-200/ төслийн хүрээнд Дорнод Монгол-VI, Дорнод Монгол-VII төслүүдийн үр дүнгийн тайланг хүлээн авснаар 100% хамрагдаж дуусна. Улсын геологийн иж бүрдэл зургийг К номенклатурын хэмжээнд 2016-2020 онд нэгтгэх төслийн К хавтгайн 65%-д буюу хийгдсэн. Монгол орны L номенклатурын хэмжээнд иж бүрдэл зургийг нэгтгэх ажлыг 2019 онд эхлүүлэхээр судалгааны ажлын геологийн даалгаврыг ТНБД-ын 2-р сарын 04-ний өдрийн шийдвэрээр, төлөвлөгөө, төсвийг УУХҮС-ын А/13 дугаар тушаалаар тус тус баталсан. Төслийн ажлыг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй гэрээг байгуулсан. L номенклатурын нь нийт нутаг дэвсгэрийн 839,481.26 кв.км буюу 53.7%-ийг эзлэх бөгөөд төлөвлөгөөт онд L хавтгайн 15 хувьд хээрийн судалгааны ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хавсралт 5, 7</p>	<p>70</p>
---	--	--	--	------------	--	-----------

<p>3. Ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх.</p>	<p>Нийт хамруулах газар нутгийн хэмжээ, хувь</p>	<p>36</p>		<p>40</p>	<p>Улсын төсвийн хөрөнгөөр 2012 оноос хэрэгжүүлсэн Бурхант толгой-50, 2013 оноос хэрэгжүүлсэн Дэвсгийн нуруу-50, 2014 оноос хэрэгжүүлсэн Улаан толгой-50, Хулгарын элс-50, Суман хад-50, Хайлааст уул-50, Чандмань уул-50, Өлийн овоот-50 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын 2019 оны 11, 110, 111, 116, 125, 126, 127, 138 дугаар тушаалуудаар хүлээн авсан. Дээрх 8 төслийг хэрэгжүүлснээр 35,549.7 кв.км талбай буюу 2.3%-ийг бүрэн хамруулсан ба нийт нутаг дэвсгэрийн 40.5%-ийг бүрэн хамруулаад байна.</p> <p>Эдгээр талбайг зураглалын ажлаар бүрхсэний үр дүнд тухайн районд тархсан төрөл бүрийн хурдас, чулуулгийн тархалт, хил зааг, найрлага, нас зэргийг тодорхойлон зураглаж, геологийн тогтоцыг нарийвчилан тогтоосон төдийгүй түүнд үндэслэн ашигт малтмалын тархалтын зүй тогтолыг тодорхойлж, хэтийн төлөвийг тодруулж, цаашид нарийвчилсэн судалгаа, эрлийн ажил гүйцэтгэх талбайг ялгасан байна. Эдгээр талбайнууд нь хуулиар хориглосон, хязгаарласан газруудтэй давхцалгүй бөгөөд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайнууд юм. Хавсралт 5, 8</p>	<p>100</p>
<p><b>Зорилт 1-ийн хэрэгжилт</b></p>	<p><b>Дүгнэлт.</b> Эрдэс баялгийн салбарын стратегийн зорилтын геологийн салбарын хөгжлийг дэмжинэ зорилтын хэрэгжилтийг хангалттай сайн гүйцэтгэн ажилласан ч ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг нийт нутаг дэвсгэрийн 40 хувьд гүйцэтгэх зорилтыг Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулахаар тусгасан ба бодлогын баримт бичгийн төлөвлөлтийг үндэслэлгүй, бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулахгүй төлөвлөж байна. Зорилтын 2, 3 дах үйл ажиллагааны биелэлтэнд судалгаанд хамрагдсан газар нутгийн хэмжээнд шинээр тогтоогдсон болон баталгаажсан металл, металл бус, шатах болон гений ус зэрэг төрөл бүрийн ашигт малтмалын илрэл, эрдэсжсэн цэг, геохими, геофизикийн гажлын талаарх мэдээллийг тайландаа дурдаж, хүрсэн үр дүнг тайлагнахгүй байна. <b>Хэрэгжсэн хувь 80%</b></p>					

<p>2.1.4. Эрдэс баялгийн салбар <b>Зорилт 2.</b> Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.</p>	<p>1. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах.</p>	<p>Уул уурхайн салбарын томоохон төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх</p>			<p>Гэрээний хэрэгжилтийг дүгнэн, гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэсэн байна.</p>	<p>Тус яамнаас уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангаж, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах ажлын хүрээнд Тавантолгойн ордын талаар авах зарим арга хэмжээний тухай" УИХ-ын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их хурлын 2018 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 73 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн дээрх тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Улсын Их Хурлын 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлагсан Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт "Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй" гэж тусган батлуулсан. Хавсралт 9.</p>	<p><b>40</b></p>	<p>Тус яамнаас байгаль орчинд ээлтэй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлж, говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох бүтээн байгуулалтыг хэрхэн зохион байгуулах асуудлыг тодорхой болгох үүднээс холбогдох хууль, тогтоомжийг боловсруулж УИХ, ЗГ-т танилцуулах ажлыг зохион байгуулаад байна.</p>
	<p><b>Зорилт 2-ын хэрэгжилт</b></p>	<p><b>Дүгнэлт.</b> Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ зорилтын хүрээнд Таван толгойн нүүрсний ордын талаар тайлагнаж, бусад Оюу толгой, Цагаан суварга зэрэг ордуудын талаар бодлогын түвшинд хэрэгжүүлсэн ажлыг тайлагнаагүй. Толгойлон хэрэгжүүлж байгаа яамны хувьд бусад яамтай хэрхэн хамтран ажилласан талаар бичээгүй байна. <b>Хэрэгжсэн хувь 40%</b></p>						

**2.1.7.БИЗНЕСИЙН ТААТАЙ ОРЧИН**

<p>2.1.7.Бизнес ийн таатай орчин</p> <p><b>Зорилт 1.</b> Худалдаа, үйлчилгээг хөнгөвчлөх, экспорт, импортын барааны тээвэрлэлтийн ложистик сүлжээг хөгжүүлэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог хялбаршуулах, татвар төлөлтийн болон улсын бүртгэлийн тогтолцоог цахимжуулж, боловсронгуй болгон бизнес эрхлэлтийн орчныг төгөлдөршүүлнэ.</p>	<p>1. Худалдаа, үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, чанарыг сайжруулах, хилийн боомт дахь байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан, хялбаршуулж гадаад худалдаанд /экспортын/ зарцуулж буй хугацааг дунджаар 25 хоног болгон бууруулж, худалдааны ертөг, зардлыг хямдруулах.</p>						0	
	<p><b>Зорилт 1-ийн хэрэгжилт</b></p>	<p><b>Дүгнэлт. Хэрэгжсэн хувь -0%</b></p>						
<p><b>2.4.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ</b></p>								

<b>2.4.ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ</b> Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь тогтвортой засаглал мөн. Тогтвортой засаглалыг хангах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал болон гадаад бодлогын үзэл баримтлал, батлан хамгаалах номлолын дагуу улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэртэй хөгжлийг бататгахад оршино.	2.4.Тогтвортой хөгжлийн засаглал <b>Зорилт 3.</b> Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авлига, хээл хахуулийг устгана.						“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм” шинэчлэн батлагдсантай холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 01-ны өдрийн 03 тоот тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны “Ёс зүйн зөвлөл”-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Ёс зүйн зөвлөл нь Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын хэмжээнд нийт ажилтан албан хаагчдад танилцуулан ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдөн ажиллаж байна. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн зөрчилтэй холбоотой ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх асуудал 2019 оны 8 дугаар сарын 30-ны байдлаар яамны хэмжээнд хэлэлцэгдээгүй болно	40		
										<b>Зорилт 3-ын хэрэгжилт</b> Дүгнэлт. Авилгатай тэмцэх газраас өгсөн шударга байдлын 2018 оны үнэлгээгээр тус яам нь сүүлийн байранд орсон ба ТЗУГ-ын асуудал хариуцсан албан хаагч нь 2016-2018 оныг хамруулан өссөн дүнгээр биелэлтийг тайлагнаагүй. <b>Хэрэгжсэн хувь -40%</b>
		<b>Зорилт 4.</b> Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцоно.							0	
									<b>Зорилт 4-ийн хэрэгжилт</b> Дүгнэлт. <b>Хэрэгжсэн хувь 0%</b>	
<b>УУХҮЯ-ны хэрэгжүүлсэн зорилт, үйл ажиллагааны үнэлгээ, хувь</b>								<b>42.0</b>		
Дангаар хэрэгжүүлсэн зорилт, үйл ажиллагааны үнэлгээ, хувь								51.0		

Толгойлон хэрэгжүүлсэн зорилт, үйл ажиллагааны үнэлгээ, хувь	40.0	
Хамтран хэрэгжүүлсэн зорилт, үйл ажиллагааны үнэлгээ, хувь	20.0	

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

Хянасан: ХШУДАГ-ын дарга

  
Г.Ганхүү

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн: ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн


мэргэжилтэн

  
Н.Баатар 19.08.30

Н.Баатар /2019.08.30/

Д.Батнайрамдал

мэргэжилтэн

  
Д.Болортуяа

Д.Болортуяа